



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

“Соёлтой иргэн-2028”
арга хэмжээ батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.8, 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Үндэсний түүх, хэл, соёлоо дээдлэн, нийслэл хотын өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, хөгжлийн үйл явцад соёлтой иргэн, хүүхэд залуусыг бэлтгэн, урлаг соёлын үйлчилгээгээр дамжуулан хотын соёлтой иргэнийг төлөвшүүлэх зорилго бүхий “Соёлтой иргэн-2028” арга хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2.Арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилтийг жил бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

D:/2025-togtool

1159199035

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны
өдрийн 06 дугаар тогтоолын хавсралт

“СОЁЛТОЙ ИРГЭН-2028” АРГА ХЭМЖЭЭ

Нэг.Нийтлэг үндэслэл

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн хэмжээнд соёл урлагийн салбарт чиглэсэн нэгдсэн бодлогыг тодорхойлж, дунд хугацааны буюу дөрвөн жилийн хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын дагуу Монгол Улсын Соёлын тухай хууль, Боловсролын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, “Алсын хараа-2025” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Соёл урлагийн чиглэлээр төрөөс баримтлах бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан “Соёлтой иргэн-2028” арга хэмжээг боловсрууллаа.

Хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн урлаг соёл, соён гэгээрүүлэх үйл ажиллагаагаар дамжуулан дүүргийн иргэд, хүүхэд, залуучуудыг хөгжүүлэн, гоо зүйн хүмүүжил олгох, соёлтой иргэн болон төлөвшихөд байнгын дэмжлэг үзүүлэх нь чухал ач холбогдолтой юм. Их хотын соёл гэдэг нь нэг нийгэм, газар нутагт амьдарч буй хүмүүс хоорондын зөв зохицол бөгөөд нийтээрээ амгалан тайван амьдрах үйл явц тул үүнийг тухайн хотын өнгө үзэмж болон иргэд, залуусын харилцааны соёлоор тодорхойлдог.

Ийм учраас үндэсний түүх, хэл, соёлоо дээдлэн, нийслэл хотын өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, хөгжлийн үйл явцад соёлтой иргэн, хүүхэд залуусыг бэлтгэн, урлаг соёлын үйлчилгээгээр дамжуулан хотын соёлтой иргэнийг төлөвшүүлэх зорилго бүхий “Соёлтой иргэн-2028” арга хэмжээг хэрэгжүүлэхээр дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан.

Чингэлтэй дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 22 дугаар тогтоолоор “Соёлтой иргэн-2024” арга хэмжээг батлуулан хэрэгжүүлж, арга хэмжээний хүрээнд урлаг соёлын болон соён гэгээрүүлэх 12 үйл ажиллагааг зохион байгуулж, тэдгээрт 100,000 гаруй хүүхэд багачууд, иргэдийг хамруулсан бөгөөд уг арга хэмжээний хүрээнд хотын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулж, урлаг соёл, соён гэгээрүүлэх үйлчилгээгээр дамжуулан хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, төлөвшүүлэх, гоо зүйн хүмүүжил олгох уралдаан тэмцээний тоо нэмэгдэж, чанар хүртээмж дээшилсэн төдийгүй байгууллагын соёл, гадаад, дотоод тохижилт

сайжирч, гэр бүлийн соёл хүмүүжлийг дээдэлж, угийн бичиг тогтмол хөтөлдөг айл өрхийн тоо нэмэгдсэн байна.

Соёлтой иргэнийг төлөвшүүлэх гол суурь зарчим нь хувийн харилцааны соёл, зөв хандлага бөгөөд дүүргийн иргэдийн дунд Хотын соёл- соёлтой иргэний тухай ойлголт мэдлэг, зөв төлөвшил, хандлага дутмаг байгаа нь “Соёлтой иргэн-2028” арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг илтгэн харуулж байна.

Хоёр.Арга хэмжээний зорилго

Үндэсний түүх, хэл, соёлоо дээдлэн, нийслэл хотынхоо өнгө үзэмж, хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулж, хөгжлийн үйл явцад соёлтой иргэн, хүүхэд залуусыг бэлтгэж, урлаг соёлын ажил үйлчилгээгээр дамжуулан “Хотын соёлтой иргэн”-ийг төлөвшүүлэхэд арга хэмжээний зорилго оршино.

Гурав.Арга хэмжээний зорилтууд, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

Зорилт 1.“Залуучуудын хөгжлийн төв”, “Гэрлэх ёслолын танхим бүхий” дүүргийн “Соёлын ордон”-г байгуулж, соёл урлагийн салбарыг бүх талаар дэмжин, бие даасан чадамжтай болгоно.

Зорилт 1-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.Соёлын ордон барих газрын асуудлыг судалж, шийдвэрлэнэ.

1.2.Соёлын ордон барих ажлыг эхлүүлж, хяналт тавих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ.

1.3.Дүүргийн соёл урлагийн салбарын арга хэмжээ, үйл ажиллагааг бүх талаар дэмжиж ажиллана.

1.4.Соёлын төвийн үйл ажиллагааг эрчимжүүлж соёл, урлагийн салбарын үйл ажиллагааг бие дааж зохион байгуулах чадамжтай болгоно.

Хүрэх үр дүн:

- Иргэд, хүүхэд, залуусын соёл урлагийн чиглэлээр үйлчлүүлэх тав тухтай тохилог орчин бий болж, соёлын үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.
- Хүүхэд багачууд, өсвөр үе, ахмад настнуудад зориулсан урлаг соёлын арга хэмжээний чанар хүртээмж, чанар, зохион байгуулалт, оролцоо, хамрагдалт нэмэгдэнэ.

Зорилт 2.

Дүүргийн иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.

Зорилт 2-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

2.1. Дүүргийн хүүхэд, залуусын авьяас, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн дугуйлан сургалтыг тогтмолжуулна.

2.2. Дүүргийн иргэд, хүүхэд залуусын урлагийн авьяас чадварыг нээн хөгжүүлэхэд чиглэсэн уралдаан, тэмцээн зохион байгуулна.

2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулахад чиглэсэн урлаг, соёлын үйл ажиллагааг зохион байгуулна.

2.4. Соёл урлаг, спортын тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээнд иргэдийг татан оролцуулна.

Хүрэх үр дүн:

- Хүүхэд, багачуудын авьяас чадварыг нээн илрүүлж, дугуйлан сургалтын чанарт ахиц дэвшил гарна.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд багачууд, өсвөр үе, ахмад настнуудад зориулсан урлаг соёлын арга хэмжээний хүртээмж, чанар, зохион байгуулалт, оролцоо, хамрагдалт нэмэгдэнэ.

Зорилт 3.

Хотын соёлтой иргэн төлөвшүүлэх талаар иргэдэд сургалт, сурталчилгаа, видео контент, нөлөөллийн ажил зохион байгуулж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчлан таниулна.

Зорилт 3-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

3.1. Иргэд, олон нийтийн эрх зөрчигдөж буй соёлгүй зан үйлүүдийн хэвшил (олон нийтийн талбай, нийтийн эзэмшлийн газарт ил задгай хог хаях, бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бие биедээ хүндэтгэлгүй хандах гэх мэт), дадал зуршлыг арилгах зорилго бүхий видео контент бэлтгэн, хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан сурталчилж, иргэдэд иргэний үүргээ биелүүлэх ухамсрыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.2. Монгол Улсын Соёлын яамнаас зохион байгуулдаг “Соёлын сэргэлт” Үндэсний хэмжээний аяныг жил бүр дүүргийн хэмжээнд уламжлал болгон өрнүүлж, боловсролын байгууллагын орчинд хүүхдийг соёлтой иргэн болгон төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Амьдралын зөв дадал хэвшлийг бий болгож, хотын соёлтой иргэнийг төлөвшүүлнэ.

Зорилт 4.

Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн агуулгыг баяжуулж, соёлын биет ба биет бус соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлж сурталчилна.

Зорилт 4-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

4.1. Дүүргийн түүх соёлын түүхэн дурсгалт газруудыг иргэд, жуулчдад таниулан сурталчлах, үндэсний урлагийн тоглолт, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдааг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

4.2. Монгол бичгийн хэрэглээг сайжруулах, хүүхэд залуусыг монгол бичигт сургахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

4.3. Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, олон нийтэд сурталчлан таниулж, үр хойч үедээ өвлүүлэн үлдээхэд дэмжлэг үзүүлнэ.

4.4. Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчийг сурталчлан алдаршуулах, өвлөн уламжлахад чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүрэх үр дүн:

- Иргэд, хүүхэд багачууд, өсвөр үеийнхний түүх соёлоо хайрлан хамгаалах үзэл төлөвшиж, соёлтой иргэн болж хөгжихөд нь түлхэц болно.

Дөрөв. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчмууд

Уялдаа холбоотой байх:

- ✓ Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, аж ахуй нэгжийн хамтын ажиллагааг бэхжүүлж, иргэдэд иргэний үүргээ үүргээ биелүүлэх ухамсрыг төлөвшүүлэхэд хэвлэл, мэдээллийн байгууллага, олон нийтийн оролцоо дэмжлэгийг авч ажиллана.

Тэгш хүртээмжтэй байх:

- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг нийгэм, соёлын үйл ажиллагаанд хамруулах, идэвхтэй оролцуулах, соёл урлаг, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхэд, залуучууд, гэр бүл, иргэдийн тэгш оролцоог хангаж ажиллана.

Шинийг санаачлагч бүтээгч байх:

- ✓ Өсвөр үе, залуучуудад зориулсан бүх төрлийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, сайн үйлсийн аян, нийгэмд эерэг зан үйлийг бий болгох чиглэлээр санаачилсан бүх үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

Үндэсний өв соёлд тулгуурлах:

- ✓ Гэр бүлийн соёл хүмүүжил, уламжлалыг дээдлэх, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хадгалан хамгаалах, сурталчлан таниулах нь соёлтой иргэн төлөвших нэг тулгуур байх зарчим баримтална.

Тав.Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1.“Соёлтой иргэн-2028” арга хэмжээг 2025-2028 он хүртэл нийт 4 жилийн хугацаанд 4 зорилт, 14 үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

5.2.Арга хэмжээний санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.2.1. Улс, нийслэлийн төсөв

5.2.2. Орон нутгийн төсөв

5.2.3. Олон улсын болон төрийн бус байгууллагын дэмжлэг

5.2.4. Бусад эх үүсвэр

Зургаа.Арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт

6.1.Арга хэмжээний хэрэгжилтийг дүүргийн Засаг даргын Тамгын газар орон нутгийн хэмжээнд удирдлага, төлөвлөлт, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

6.2.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус, олон улсын байгууллага, соёл урлагийн салбарын мэргэжлийн байгууллага, холбоод, иргэд, олон нийт, хүүхэд, залуучууд, ахмад настнууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжлэг тусалцаа, идэвх оролцоог хангаж ажиллана.

6.3.Арга хэмжээний хэрэгжилтийг хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол сурталчлан ажиллах ба соёл урлагийн чиглэлээр сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, нутагшуулах чиглэлд анхаарч ажиллана.

Долоо.Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ, үр дүн, шалгуур үзүүлэлт

Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь оролцогч талуудыг тэгш оролцоог хангаж, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ба үр дүнгийн хэрэгжилтийг жил бүр гаргаж, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн хуралдаанд тайлагнана.
- Арга хэмжээний хэрэгжилтийг зорилтын биелэлт, үйл ажиллагааны чиглэлийн үр дүнгээр үнэлнэ.

Арга хэмжээний үр дүн:

- Хүүхэд багачуудад бага наснаас нь хотын иргэний соёл төлөвшиж, эрхээ эдэлж, үүргээ ухамсарлах ёс зүйтэй болсон байна.
- Монгол өв уламжлалд суурилсан соёлын зөв хандлага төлөвшиж, өв соёлоо тээгч, хадгалан хамгаалдаг иргэдийн тоо нэмэгдсэн байна.
- Хотын өнгө үзэмж, цэвэр цэмцгэр байдал иргэдийн ухамсартай холбогдож, сайжирсан байна.

Шалгуур үзүүлэлт:

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин			
				2025 он	2026 он	2027 он	2028 он
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. "Залуучуудын хөгжлийн төв", "Гэрлэх ёслолын танхим бүхий" дүүргийн "Соёлын ордон"-г байгуулж, соёл урлагийн салбарыг бүх талаар дэмжин, бие даасан чадамжтай болгоно.							
1.1	1.1.1.Соёлын ордонг барьж байгуулсан эсэх	хувь	0	50	100	100	100
1.2	1.2.1.Тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангамжийн хувь	хувь	70	70	100	100	100
1.3	1.3.1.Дүүргийн хэмжээнд зохион байгуулсан соёл урлагийн арга хэмжээ, үйл ажиллагааны тоо	тоо	24	36	36	36	36
1.4	1.4.1.Соёлын төвийн үйл ажиллагааны чанар хүртээмж, соёл, урлагийн салбарын бие даасан байдал	хувь	30	50	70	100	100
Зорилт 2. Дүүргийн иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.							
2.1	2.1.1.Дүүргийн хүүхэд, залуусын авьяас, чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн дугуйлан сургалтын тоо	тоо	5	9	10	10	10
	2.1.2.Хамрагдсан хүүхдийн тоо	тоо	56	100	120	120	120

2.2	2.2.1.Дүүргийн иргэд, хүүхэд залуусын урлагийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан уралдаан, тэмцээний тоо	тоо	5	12	12	12	12
	2.2.2.Уралдаан тэмцээнд хамрагдсан иргэд, хүүхэд залуусын тоо	тоо	3,000	4,000	4,000	4,000	4,000
2.3	2.3.1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах чиглэлээр зохион байгуулсан урлаг, соёлын үйл ажиллагааны тоо	тоо	2	5	5	5	5
	2.3.2.Үйл ажиллагаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо	тоо	100	150	150	150	150
2.4	2.4.1.Тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд соёл, урлагийн чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо	тоо	2	6	6	6	6
	2.4.2.Үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн тоо	тоо	30,000	35,000	35,000	35,000	35,000
Зорилт 3.Хотын соёлтой иргэн төлөвшүүлэх талаар иргэдэд сургалт, сурталчилгаа, видео контент, нөлөөллийн ажил зохион байгуулж, хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр дамжуулан сурталчлан таниулна.							
3.1	Хотын соёлын сурталчлан таниулах чиглэлээр бэлтгэсэн видео контентын тоо	тоо	2	5	5	5	5
3.2	3.2.1 "Соёлын сэргэлт" аяны хүрээнд зохион	тоо	0	5	5	5	5

	байгуулсан арга хэмжээний тоо							
	3.2.2 "Соёлын сэргэлт" аянд хамрагдсан иргэд, хүүхэд, залуусын тоо	тоо	0	200	200	200	200	200
Зорилт 4.Монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний үнэт зүйлээ дээдэлсэн агуулгыг баяжуулж, соёлын биет ба биет бус соёлыг олон нийтэд түгээн дэлгэрүүлж сурталчилна.								
4.1	4.1.1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд зохион байгуулсан үзэсгэлэн худалдааны тоо	тоо	1	1	1	1	1	1
	4.1.2.Үндэсний урлагийн тоглолтын тоо		1	1	1	1	1	1
4.2	4.2.1.Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо	тоо	1	3	3	3	3	3
	4.2.2.Хамрагдалтын хувь	хувь	-	30	50	70	100	
	4.2.3.Төрийн албан хаагчдыг Монголын бичгийн сургалтад хамруулсан хувь хэмжээ	хувь	-	30	50	70	100	
4.3	Улс, нийслэл, дүүргийн хамгаалалтад авсан соёлын биет өвийг бүртгэлжүүлж, үндэсний хэл бичгээр хаягжуулах	тоо	26	26	26	26	26	26
4.4	Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчийг алдаршуулах олон талт арга хэмжээг зохион байгуулсан тоо	тоо	1	2	3	3	4	